

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/46/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 51-260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Эрдэнэзул Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас:976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН
ХАНГАМЖИЙН ҮР АШГИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Э.МӨНДӨР ТАНАА

2024.02.23 № 07/368
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3,361,255.3 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй, оршин байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл нь Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээгээр 2020 оноос 2025 оныг дуустал хэрэгжинэ.

Төсөл нь 2020 оноос 2023 онд төсөл хөтөлбөрийн гэрээний төлбөр тооцоонд 65,666,877.7 мянган төгрөгийг зарцуулснаас, хэрэгжүүлэгч байгууллага УБДС ТӨХК нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулан 32,365,884.6 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн балансад тусгасан байна.

Аудитын гол асуудал

Төслийн 2023 оны Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд төслийн нийт хугацааны төлөвлөгөөний биелэлт 54.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Төслийн удирдах хорооны 2022 оны 4 дүгээр тогтоолоор 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний санхүүжилтийг 2 хөтөлбөрийн хүрээнд 84 арга хэмжээ хэрэгжүүлэхээр 32,066,564.2 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна. Төслийн удирдах хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, 12 арга хэмжээнд 7,161,345.6 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж, тайлант оны нийт санхүүжилтийн төсвийг 39,227,909.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,314,809,738.43	4,342,921,122.76
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,314,809,738.43	4,290,703,864.60
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,314,809,738.43	4,290,703,864.60
31210	Төгрөг	33,002,533.73	124,057,448.26
31225	Төрийн сангийн харилцах	33,002,533.73	124,057,448.26
31220	Гадаад валют	2,281,807,204.70	4,166,646,416.34
31223	Төрийн сангийн харилцах	2,281,807,204.70	4,166,646,416.34
35	АВЛАГА	-	52,217,258.16
350	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	52,217,258.16
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	369,630,295.68	288,784,132.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	369,630,295.68	288,784,132.35
39200	Биет хөрөнгө	359,970,295.64	281,780,798.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	336,363,636.37	336,363,636.37
39204	Хуримтлагдсан элэгдэл	(83,186,705.87)	(139,247,312.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,239,779.00	74,821,506.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,240,752.86)	(29,925,005.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,550,609.00	65,550,609.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,756,270.00)	(25,782,635.28)
39300	Биет бус хөрөнгө	9,660,000.04	7,003,333.36
39301	Программ хангамж	11,350,000.00	11,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,689,999.96)	(4,346,666.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,684,440,034.11	4,631,705,255.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,909,090.93	52,458,408.19
413	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,909,090.93	52,458,408.19
4136	Өглөг	10,909,090.93	86,676.26
41360	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	86,676.26
413	Бусад өглөг	10,909,090.93	52,371,731.93
41361	Байгууллагад төлөх өглөг	10,909,090.93	52,371,731.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,673,530,943.18	4,579,246,846.92
51	Засгийн газрын хувь оролцоо	2,673,530,943.18	4,579,246,846.92
512	Хуримтлагдсан үр дүн	2,673,530,943.18	4,579,246,846.92
51210	Өмнөх үеийн үр дүн	10,773,172,486.19	2,673,530,943.18
51220	Тайлант үеийн үр дүн	(8,099,641,543.01)	1,905,715,903.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,684,440,034.11	4,631,705,255.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	21,186,822,500.00	39,489,533,353.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,186,822,500.00	39,489,533,353.67
120	Нийтлэг татварын бус орлого	21,175,622,500.00	39,483,783,353.67
120044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	21,175,622,500.00	39,483,783,353.67
1200044	Зээлийн шууд санхүүжилтийн орлого	11,200,000.00	5,750,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	736,486,095.90	1,402,495,968.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	736,486,095.90	1,402,495,968.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	736,486,095.90	1,402,495,968.11
210101	Үндсэн цалин	410,725,607.72	490,969,308.09
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	51,223,935.17	61,257,928.18
210304	Байрны түрээсийн зардал	62,702,726.79	67,116,417.00
210401	Бичиг хэргийн материал	5,553,404.52	7,035,617.53
210402	Тээвэр, шатахууны зардал	8,024,500.00	8,750,000.00
210403	Шуудан холбооны зардал	2,882,685.04	1,834,165.19
210404	Ном, хэвлэл	184,680.00	-
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	2,959,542.72	3,955,728.16
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	7,110,341.00	18,298,200.00
210604	Урсгал засвар	5,681,263.65	10,353,753.89
210701	Гадаад албан томилолт	-	421,307,766.84
210702	Дотоод албан томилолт	1,758,320.00	3,189,742.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	94,957,890.41	93,217,991.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,714,375.90	198,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	78,006,822.98	81,427,890.60
210904	Хаагдсан данс	-	133,583,059.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	20,450,336,404.10	38,087,037,385.56
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	1,037,945,318.86	-
225000	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	1,037,945,318.86	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	29,587,923,265.97	36,181,321,481.82
225001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	-	102,367,079.13
120044	Гадаад төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх	29,587,923,265.97	36,078,954,402.69
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(8,099,641,543.01)	1,905,715,903.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	21,186,822,500.00	29,673,328,671.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,186,822,500.00	29,673,328,671.54
120	Төсөвт байгууллагын өөрийн орлого	21,186,822,500.00	29,673,328,671.54
1200044	Зээлийн санхүүжилт	21,175,622,500.00	29,667,578,671.54
1200042	Туслах үйл ажиллагаанаас санхүүжих	11,200,000.00	5,750,000.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	-	10,127,878.44
21	Бараа, ажил үйлчилгээний зардал	-	10,127,878.44
210901	Бараа, ажил үйлчилгээний зардал	-	10,127,878.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	21,186,822,500.00	29,663,200,793.10
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	-	581,727.27
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	581,727.27
2200	Дотоод эх үүсвэрээр	-	581,727.27
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	581,727.27
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(581,727.27)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	Бусад эх үүсвэр	1,037,945,318.86	-
225000	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,037,945,318.86	-
9	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	25,518,673,060.24	27,584,357,860.53
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	25,518,673,060.24	27,584,357,860.53
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	102,367,079.13
225001	Гадаад валютын ханшийн зарүүний гарз	-	102,367,079.13
11	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(24,480,727,741.38)	(27,686,724,939.66)
12	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,293,905,241.38)	1,975,894,126.17
13	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,608,714,979.81	2,314,809,738.43
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,314,809,738.43	4,290,703,864.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	10,773,172,486.19	10,773,172,486.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	10,773,172,486.19	10,773,172,486.19
Тайлант үеийн үр дүн		(8,099,641,543.01)	(8,099,641,543.01)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,673,530,943.18	2,673,530,943.18
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,673,530,943.18	2,673,530,943.18
Тайлант үеийн үр дүн		1,905,715,903.74	1,905,715,903.74
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	4,579,246,846.92	4,579,246,846.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,429,000,000.00	37,401,144,269.93	27,855,730.07	99.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	37,429,000,000.00	37,401,144,269.93	27,855,730.07	99.9
Гадаадын санхүүгийн зээлээс санхүүжих зээл	37,429,000,000.00	37,401,144,269.93	27,855,730.07	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	37,429,000,000.00	39,483,783,353.67	(2,054,783,353.67)	105.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	37,429,000,000.00	39,483,783,353.67	(2,054,783,353.67)	105.5
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	37,429,000,000.00	39,483,783,353.67	(2,054,783,353.67)	105.5
Тохируулах бичилт				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,310,431,859.99		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,290,703,864.60		
БАЙГУУЛЛАГЫН ТОО				
Төсвийн байгууллага	1	1		100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	13		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	10	10		100.0
Гэрээт ажилтан	2	2		100.0

Гурав: Аудитын илрүүлэлт:

Аудитаар Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн тайлагнаж ирүүлээгүй, Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангуудыг 2 оноор зэрэгцүүлээгүй, бүрэн тайлагнаагүй, гүйцэтгэгч байгууллагуудын дуусаагүй гэрээний санхүүжилтийн үлдэгдэл 3,361,255.3 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зөрчлийг давтан гаргасан тул тайланг залруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд нийцүүлээгүй, тайлангийн иж бүрдэл дутуу ирүүлсэн байна. Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангуудыг 2 оноор зэрэгцүүлээгүй, өмнөх оны аудитаар санхүүгийн тайланг иж бүрэн тайлагнах аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-	1	-		
2	Төслийн нийт хугацаанд гэрээний төлбөр тооцоонд 65,666,877.7 мянган төгрөг зарцуулснаас УБДС ТӨХК нь тооцоо нийлсэн актаар 32,365,884.6 мянган төгрөгийг өөрийн балансд тусгасан байна. Зарцуулалтын зөрүү 33,300,993.1 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардалд тайлагнаагүй, үүнээс 3,361,255.3 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	3,361,255.3	1	3,361,255.3		
Дүн		2	3,361,255.3	2	3,361,255.3		

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулаагүй 33,689,836.19 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл хангалтгүй 22,354,505.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 158 мэдээллээс 151 мэдээлэл хугацаанд нь байршуулж, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, дараа жилийн төсвийн төсөл 33,689,836.1 мянган төгрөгийн 2 мэдээг хугацаа хоцроосон зөрчилтэй.	1	33,689,836.1			1	33,689,836.1

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

2	34,877,490.3 мянган төгрөгийн төсөвтэй 20 худалдан авалт зохион байгуулахаар төлөвлөснөөс Дэлхийн банкны шаардлагаар зураг төсөв өөрчилсөн, тендерийн баримт бичиг шаардлага хангаагүй, шаардлага хангасан тендер ирээгүй 22,354,505.9 мянган төгрөгийн 10 худалдан авалт хийгдээгүй, төлөвлөгөөний гүйцэтгэл 50.0 хувьтай байна.	1	22,354,505.9	1	22,354,505.9		
Дүн		2	56,044,342.0	1	22,354,505.9	1	33,689,836.1